



12

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
Т О Г Т О О Л

2000 оны 11 дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 185

Улаанбаатар  
хот

Нийслэлийн Засаг даргын Тамгын  
газар, Захирагчийн ажлын албаны  
бүтцийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 61 дүгээр зүйлийн 4, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1,3, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дор дурдсанаар тогтоосугай:

- а/ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс;
- б/ Эдийн засаг, стратегийн бодлогын хэлтэс;
- в/ Санхүүгийн бодлогын хэлтэс;
- г/ Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс;
- д/ Хууль зүйн хэлтэс;
- е/ Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс.

2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргад Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын үүргийг давхар хариуцуулсугай.

3. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтцийг дараахь байдлаар тогтоосугай:

- а/ Инженерийн байгууламжийн хэлтэс;
- б/ Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс;
- в/ Хот тохижилтын хэлтэс;
- г/ Мэргэжлийн хяналтын хэлтэс.

4. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг 55 хүртэл, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг 43 хүртэл, нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-уул, Чингэлтэй дүүрэгт 42 хүртэл, Багануур, Налайх дүүрэгт

38 хүртэл, Багахангай дүүрэгт 23 хүртэл /үйлчилгээний орлогоос цалинждаг болон нормативаар ажиллах орон тоо орохгүй/ байхаар тогтоосугай.

5. Нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай тохиролцсоны үндсэн дээр тогтоон мөрдүүлэхийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч М.Энхболдод зөвшөөрсүгэй.

6. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий дараахь хэрэгжүүлэгч агентлагуудыг ажиллуулахаар тогтоосугай:

- а/ Татварын газар;
- б/ Өмчийн харилцааны газар;
- в/ Хот байгуулалт, газрын харилцааны газар;
- г/ Цагдаагийн газар;
- д/ Цэрэг-иргэний хамгаалалтын штаб;
- е/ Эрүүл мэндийн газар /Эрүүл мэндийн хяналтын албатай/;
- ж/ Боловсролын газар;
- з/ Соёлын газар;
- и/ Санхүүгийн хяналт шалгалтын газар;
- к/ Статистик, мэдээлэл, судалгааны газар;
- л/ Нийгмийн даатгалын газар;
- м/ Байгаль орчин, экологийн хяналтын газар;
- н/ Биеийн тамир, спортын хороо;
- о/ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын алба;
- п/ Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;
- р/ Нийтлэг үйлчилгээний газар;
- с/ Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэн;
- т/ Архивын алба;
- у/ Гаалийн газар;
- ү/ Мал эмнэлэг, хяналтын газар;
- ф/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба;
- х/ Гал түймэртэй тэмцэх хэлтэс.

7. Улаанбаатар хотын Захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд дараахь байгууллагуудыг ажиллуулахаар тогтоосугай:

- а/ Ус суваг ашиглалтын газар;
- б/ Орон сууц, нийтийн аж ахуйн газар;
- в/ Хөрөнгө оруулалтын газар;
- г/ Тээврийн газар;
- д/ Халаалтын зуухны ашиглалтын газар;

- е/ Үндэсний соёл амралтын хүрээлэн;
- ж/ Иргэдэд үйлчлэх "Буян" компани;
- з/ "Улаанбаатар зам засвар" компани;
- и/ "Гэрэлтүүлэг-чимэглэл" компани;
- к/ "Нөөц" компани;
- л/ "Цэцэрлэгжилт" компани;
- м/ "Улаанбаатар-ус" компани.

8. Нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг, Захирагчийн харъяа газруудын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоон мөрдүүлэхийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч М.Энхболдод зөвшөөрсүгэй.

9. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 263 дугаар тогтоолын 2,3,5 дугаар зүйл, "Бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 108 дугаар тогтоол, "Статистикийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1998 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 27 дугаар тогтоолын 3 дугаар зүйл, "Төрийн архивын харьяаллын тухай" Засгийн газрын 1998 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 124 дүгээр тогтоол, "Тогтоолуудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2000 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 71 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Засгийн газрын гишүүн,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга

Н.ЭНХБАЯР

Ө.ЭНХТҮВШИН